



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 25

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 500,000 (Таван зуун мянга) төгрөгийн балансын үнэтэй үлдэх өртөггүй 45-90 ДУА улсын дугаартай KIA FRONTER автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гурвансайхан сумын Засаг дарга (Б.Энхтуяа), Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Ж.МӨНХЧУЛУУН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн  
25 дугаар тогтоолын хавсралт



Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын  
актлах хөрөнгийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон он	Санхүүгийн тайланд тусгагдсан дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	Дугаар					
1	Гурвансайхан сумын ЗДТГ	Kia fronter	ДУА	4590	2009	2009	500,000	500,000	0.00
Нийт							500,000 (таван зуун мянга) төгрөг	500,000 (таван зуун мянга) төгрөг	-